

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

2022.12.09

Алтай хот

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2022 оны хэрэгжилтэд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 онд хэрэгжүүлсэн 111 зорилтын 62 нь үр дүнтэй, 41 нь тодорхой үр дүнд хүрсэн, 7 нь эрчимжүүлэх шаардлагатай, 1 нь үр дүнгүй үнэлэгдлээ.

2."Эрчимжүүлэх шаардлагатай" 7 зорилт байгаа бөгөөд эдгээрийн 6 нь хөрөнгө, санхүүгийн асуудлаас, 1 нь гадаад хүчин зүйлээс шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байна.

3."Үр дүнгүй" 1 зорилт байгаа бөгөөд энэ нь төсөв санхүүгийн асуудлаас шалтгаалан аймгийн төвийн гэр хорооллын хяналтын камертай гудамжны тоог нэмэгдүүлэх ажил хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Төрийн захиргааны удирдлагын хэлтэст:

1.Эрчимжүүлэх шаардлагатай болон үр дүнгүй үнэлэгдсэн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн Засаг даргын сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ болон агентлагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хангуулах;

2.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээнээс сумдад хамаарах заалтыг тусад нь картлан хүргүүлэх;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС